

Тахийн мэдээ



№ 7 | 2018 оны 8-р сар

Говь нутгийн ирээдүй

Говь нутгийн амьдрах орчны талаарх олон асуудлыг бид хараахан шийдэж чадаагүй л байна. Ирээдүйг нь баталгаажуулахын тулд хэрэгцээ, шаардлагыг нь улам их ойлгох шаардлагатай юм.

Зургийг: Ребякка Блумер

Тахь болон түүний амьдрах орчинг хамтдаа хамгаалцгаая.

Тахийг хайрлан хамгаалдаг эрхэм андууд аа!



Бидний амьдарч буй дэлхий ертөнцөд хүний нөлөө ороогүй газар бараг үгүй болжээ. Зэрлэг амьтад, түүний амьдрах орчин дэлхий дахинаа хэсэгчлэн, тусгаарлагдах болсон. Онгон зэрлэг байгаль нь зөвхөн дархан цаазат, байгалийн цогцолбор газарт л байх ба экологийн хувьд авч үзэхэд хэтэрхий бага байгаа юм. Тэр ч байтугай хамгаалалттай бүс нутгийн төрөл зүйл нь хэдий чинээ бага, хамгаалагдсан байна төдий чинээ тэсэж үлдэж байна. Амьдрах орчны тусгаарлал гэдэг нь нэг ёсны эмгэнэл. Тийм ч учраас ховор зүйлүүд тусгаарлагдан хадгалагдаж үлдсэн газар нутгийг хооронд нь холбох нэн чухал асуудал юм.

Дэлхий дээр том газар нутгийг хамарсан, харьцангуй бүрэн бүтнээрээ үлдсэн тал нутгийн экосистем нь Төв Азид л байна. Энэхүү хуурай, ой модгүй, өвс, бут сөөглөг газар нутаг нь үржил шим багатай харагдах боловч амьдралын өвөрмөц шинж чанартай төрөл зүйл амьдардаг. Жишээ нь Тахь, хулан, хар сүүлт зээр, бөхөн ба бусад том, жижиг хөхтөн амьтад, шувууд, хэвлээр явагчид, сээр нуруугүйтэн болон тал нутагт зохицсон ургамлын төрөл зүйлүүд байдаг.

Тал хээр нутагт өвс тэжээл, ус ундааны хангамж нь тарчиг, хурдан хувьсан өөрчлөгдөх тул зэрлэг амьтдын хувьд нүүдэллэн амьдрах шаардлага бий болдог. Ийм ч учраас аливаад хил хязгаар тогтоох нь асуудал болж, мухардалд оруулж байна. Өргөстэй төмөр утсан хилийн зурвас, хоолойн шугам, энгийн хашаа, зам, төмөр зам зэрэг нь давж тууламгүй саад бэрхшээлийг бий болгож байна. Энэ нь нүүдэллэх, олон зуун жил дасан нутагшиж ирсэн төрөл зүйл амьтдыг сүйтгэх нөхцөл болж байна.

Эдгээр төрөл зүйл амьтдыг хадгалан авч үлдэхийн тулд олон улсын түвшинд бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага гарч байгаа юм. Иймд нүүдлийн зэрлэг амьтдын төрөл зүйлийг хамгаалах конвенц-д /Боннын конвенци хэмээн нэрлэдэг/ Швейцарь улсын төлөөлөгчдийн тэргүүний хувьд миний эн тэргүүний зорилтуудын нэг энэ болж байна.

Олон Улсын Тахь Группийн хувьд Монголын Говийн Их Дархан Цаазат Газрын "Б" бүсийн газар нутгийг өргөжүүлэх, Монгол, Хятадын хил залгасан хамгаалалттай нутгуудыг холбох асуудлыг дэмжин ажиллаж байгаа ба энэ нь Төв Азийн Том Хөхтөн амьтдыг хамгаалах санаачлагын нэг Төв Азийн хөхтөн амьтдыг хамгаалах санаачлага ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй зорилго нь нийцэж байгаа юм.

Ховор зүйл амьтдыг үр дүнтэй хамгаалахын тулд бид тэдгээрийн цаашдын хэрэгцээ шаардлага буюу 21-р зуунд тулгарч буй тэдгээрийн бодит байдлыг ойлгох шаардлагатай тулгарч байна. Мэдээж хийх нь ярихаас хэцүү шүү дээ.

Мөн олон чухал асуудлууд өнөөдөр хариултгүй үлдэж байна. Иймээс бид ховор амьтад, түүний амьдрах орчны хомсдлын олон талт асуудлыг олж мэдэхийн тулд нухацтай судалж, хамгааллын арга хэмжээ авах шаардлага байгаа юм.

Нутгийн иргэдийн орлогын анхдагч эх үүсвэр болсон ноолуурын чиглэлийн ямааны өсөлт, бэлчээрээр дамжин гарч буй халдварт өвчнүүдийн тархалтыг хэрхэн зогсоох вэ? Эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс газрын баялгийг хайх, олборлох нь тал хээрийн амьтдыг хамгаалахтай хэр нийцтэй вэ? Цаашид бид өсөн нэмэгдэж буй боловч эмзэг хэвээр байгаа тахийн сүргийг хэрхэн хамгаалах вэ, аялал жуулчлал нь Говийн дархан цаазат газрыг хамгаалах санхүүгийн эх үүсвэр болох боломжтой юу? зэрэг асуудлууд гарч ирсээр байна. Эдгээр асуудлуудыг бид амжилттай шийдэж чадвал тахь болон бусад ховор зэрлэг амьтдын амьдрах орчныг хамтдаа хамгаалж чадах юм. Бид ухрах аргагүй! Бидэнд хийх ажил их байгаа ч зорьсон үйлсээ ажил хэрэг болгоход дэмжих өгөөмөр хүмүүс, тал шигээ уудам сэтгэлтэй хүмүүсийн тусламж, дэмжлэгтэйгээр л бид үүнийг хэрэгжүүлэх боломжтой юм. Магадгүй та ч байж болох юм?

Др.Райнхард Шнидриг,

Олон Улсын Тахь Группийн ерөнхийлөгч

Дэлхий дээр том газар нутгийг хамарсан, харьцангуй бүрэн бүтнээрээ үлдсэн тал нутгийн экосистем нь Төв Азид л байна.

Зургийг: Петра Каченски

Тахийн сүрэгт бэлчээр хэрэгтэй!

Говийн Их Дархан Цаазат Газрын “Б” бүс нутгийг дан ганц онгон байгалийн зориулалтаар хадгалж хамгаалж ирээгүй бөгөөд эрт үеэс нүүдэлчид ашигласаар ирсэн уламжлалтай. Нутгийн иргэд өвлийн улиралд хамгаалалттай бүс нутагт нэвтэрч мал сүргээ өвөлжүүлдэг. Тус бүс нутгийн тарчиг өвс, ургамал нь хулан, зээр тахид ч ач холбогдолтой ба энэ нь цаашид шийдэх олон асуудлыг хөндөж буй юм. Унд усны асуудлын өрсөлдөөн хэр их байна вэ? Нүүдэлчин айл өрхийн тоо багасч буй хэдий ч ноолуурын чиглэлийн ямааны тоо толгой нэмэгдсэнтэй холбоотой өрсөлдөөн нэмэгдэж байна уу? Хүний хөл хөдөлгөөн ихсэх тусам зэрлэг амьтад угаас тарчиг өвс бэлчээрлүү шахагдаж байна уу, эсвэл мал сүрэгтэй хамт бэлчиг байна уу? – тийм бол яаж?

Говийн их дархан цаазат газрын “Б” бүсэд байгаа 13,000 толгой хар сүүлт зээр, 9,000 толгой хулан, 200 толгой тахь тусгай экологийн бүсэд амьдарч чадаж байна уу эсвэл малын бэлчээрийг хуваалцаж, тэднээс хамаарч байна уу? Олон улсын судлаачид хулан, тахь, таван хошуу малын идэш тэжээлийг судалж, тэдний сүүлний үсэнд дүн шинжилгээ хийжээ.¹ Удаан, тогтвортой ургах явцад сантиметр сантиметрээр нэмэгдэх бат бөх нүүрстөрөгчийн – Изотоп (өөр өөр атомын жинтэй атомууд) хэмээх бодисыг хүнс тэжээлээрээ бий болгогчийг олж судалжээ. Тэдгээрийн хэмжээ нь ямар ургамлын

төрөл зүйл идсэнээс хамааран ялгаатай байсан байна. Сүүлний үсний ургалтын хурдыг сайн олж харж чадаж байвал сүүлний үсийг бага багаар шатаан, массын спектрометрээр нүүрстөрөгчийг шинжилж болох бөгөөд улирлын өвс тэжээлийг олж мэдэх боломжтой. Үүний үр дүнд хулан зундаа голдуу өвслөг ургамлаар хооллож, өвөлдөө жижиг бут сөөг ургамалаар хооллодог болохыг мэджээ. Мөн тэд устай газраас хол бэлчээрлэх ба хуурайшилд тэсвэртэй байдаг бол монгол адуу ба тахь нь эсрэгээрээ цэвэр бэлчээрийн өвс тэжээл иддэг амьтад юм. Өвөл буюу хамгийн их хүч сорьсон улиралд тэд өөр хүнс тэжээлд шилжиж чадахгүй. Иймээс тэд хамгийн сайн өвс тэжээлтэй усны ундаргууд дээр цуглардаг ба адуу, малтай нүүр тулгардаг. Энэ нь цөөн тооны тахийн сүргийн хувьд асуудал юм. Мал ба зэрлэг амьтдын амьдрах орчинг сайжруулахын тул тусгай хамгаалалттай нутгийн бэлчээрт тодорхой журам, зохицуулга байх нь зүйтэй хэмээн судлаачид үзэж буй ба энэ нь олон улсын тахь группийн хийх ажил юм!

1 Мартина Бурник Штурм, О.Ганбаатар, Христиан С. Войгт болон Петра Каченски: Монголын говийн адууны овгийн ойр төрлийн 3 зүйлд идэш тэжээлийн ялгааг тогтоох дараалсан тогтвортой изотопын судалгаа, Хавсрага экологийн сэтгүүл 2017, 54, 1110–1119, doi: 10.1111/1365-2664.12825



Зургийг: Ребякка Блумер

Хүн, малын нөлөө ихэссэнтэй холбоотой хулан, тахийн бэлчээрлэх газар багасчээ. Нөөцөд гарч байгаа зөрчлийг цаашид хэрхэн тогтвортой зохицуулах нь одоохондоо шийдэгдээгүй ба шийдвэл зохих, чухал асуудал хэвээр байна.

Зүүнгарын говь дахь изотопийн судалгаа

Бат бөх Изотоп (өөр өөр атомын жинтэй атомууд) нь байгалийн зүй тогтлыг тод томруун харуулах мэдээллийн сан болдог байна. Тундасжсан нийтлэг изотопийн хэв загварыг зэрлэг амьтдын нүүдэл, нотлох баримт, гарал үүслийн нотолгоо зэргээр ашигладаг байна. Гэвч багадаа жилийн дотор ийм төрлийн мэдээллийг цуглуулах цөөн хэдэн зуун газар л дэлхий дээр байдаг. Саяхнаас Монголын Зүүнгарын говь энэ төрөл газарт багтаж байгаа ба Мартина Бурник Штурм болон Петра Каченски (Венийн мал эмнэлгийн их сургуулийн зэрлэг амьтдын экологийг судлах институт) нар тунадас, гол ба бусад усан биетүүдэд байгаа устөрөгч, хүчилтөрөгчийг энд анх хэмжсэн судалсан.² Тэдний судалгааны мэдээлэл нь үүссэн изотопийн мэдээллээс гажуудсан бөгөөд Зүүнгарын говь мэтийн онцгой цаг уурын бүсүүдэд изотопийн үнэлэмжийг бий болгох нь хүндрэлтэй зүйл юм.


2 Мартина Бурник Штурм, Оюунсайханы Ганбаатар, Христиан С.Войгт, Петра Каченски: Монгол орны баруун өмнөд хэсэгт орших Зүүнгарын говийн гол, усны амьд биет болон хур тунадасны $\delta^{15}\text{N}$ ба $\delta^{18}\text{O}$ хэмжээнд суурилсан хээрийн анхны судалгааны ажиглалт. Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн судалгааны изотоп, 2016 он, <https://doi.org/10.108>

Говийн Их Дархан Цаазат Газрын "Б" бүс дэх тахийн тоо толгой мэдээ

Говийн их дархан цаазат газрын "Б" бүс нь Монголын баруун урд хэсэгт байрлах, далайн түвшнээс 1200 м ба уулсаар хүрээлүүлсэн Зүүнгарын говьд оршдог. Тахь зэрлэг байгальдаа устахаасаа өмнө буюу 20-р зууны 60-аад онд энд дэлхийн хамгийн сүүлчийн тахь зэрлэг байгальдаа үзэгдсэн байдаг. Энэхүү бүс нутагт амьтны хүрээлэнд үлдсэн тахийн сүргээс нэлээд тахийг зэрлэг байгальд нь эргүүлэн нутагшуулсан юм. Байгалийн хатуу ширүүнийг тэсвэрлэн тоо толгой нь зохих хувиар өсөн үржсээр байна. Гэвч 2009/2010 оны өвлийн зуднаар сүргийн гуравны хоёр нь хорогдсон юм. Үүнээс хойш дахин үржиж, 2018 оны 5-р сард тахийн сүргийн тоо толгой нь 223 (23 нь унага) болон сэргээн нутагшуулах хугацааны туршид оргил үедээ хүрчээ. Гэсэн хэдий ч энэ тоо байгальд харьцангуй бага, эмзэг тул тахийн сүргийг хамгаалах шаардлагатай юм. Үүнээс гадна хамтын хэрэглээний уст цэгүүд болон бэлчээрүүд дээр мал сүргээр дамжин тархах халдварт өвчнүүд байнгын санаа зовоож байна. 2015 оноос тахийн эзлэх орон зайн эзэмшил нутаг нэмэгдэж байгаа нь сайны дохио бөгөөд урьд өмнө тусгай хамгаалалттай газрын нөөцийг бага ашигладаг байсан бол одоо зэрлэг байгальдаа бүрэн дасан зохицон амьдарч байна. Энэ нь нэг талаараа маш нарийн мониторинг хийх нөхцлийг хүндрүүлж байна. Дунд хугацаандаа нэгжээс (нэгжээс сүргийн бүтцийн хөдөлгөөнийг нарийвчлан харах боломж) бүхэлд нь хянах одоогийн хяналтаас өөрт шилжих стратегийн өөрчлөлт хийх шаардлага гарч болох юм.


Сүргийн бүтцийг сайжруулах, генетикийн солилцоо нь багасч байгаа тул тээвэрлэлтийн арга барил өөрчлөгдөж ч болох юм.

Говийн их дархан цаазат газрын "Б" бүсийн хамгаалалтын захиргаа болон Олон улсын тахь группийн мэргэжилтэн, эрдэмтэд тахийн менежментийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох шинэ менежментийн төлөвлөгөө болон "Б" бүсийн тулгамдаж буй асуудлууд дээр ч гэсэн ажиллаж байгаа билээ.



Энэ жил сүргийн хооронд олон солилцоо, өөрчлөлт гарсан. Гэвч сүргийн хэмжээ ойролцоогоор 10 байв. Үрээ -1 сүргийн үр төлийн хувьд 50%-иар нэмэгдсэн байна. Харин үрээ- 2 сүргийн хувьд өсөж яваа залуу азарга Цуут ганцаараа юм.

Тахийн сүргийн хүйсний бүтэц, 2018 оны 6 сар



Говийн Их дархан цаазат газрын "Б" бүсийн тахийн сүргийн 2/3 нь гүү юм. Энэ нь сүргийн тоо толгойг өсгөх хамгийн зохимжтой харьцаа ажээ. Харин тахийн үр төлийн хувьд (20% нь эм, 22% эр төл) тэнцвэртэй ба энэ нь сүргийн тоо толгойг ирээдүйд өсөх эсвэл багасахад ач холбогдолтой байдаг байна.

"Цуут" нэртэй тахийн үрээ дахиад ганцаараа

Бидний "Тахийн мэдээ" сонинг тогтмол уншдаг уншигчид 2015 оны 8-р сарын дундуур эхээ алдсан Цуут хэмээх унагыг санаж байгаа байх. Унага долоо хоногийн турш ганцаараа байж амьд гарсан. Үрэгдэж магадгүй байсан, тахийн жижигхэн унага 10-р сарын эхээр айлын адуун сүрэгт нийлэн орж ирсэн нь үнэхээр гайхалтай зүйл байлаа. Түүнийг барьж, ачааны битүү тэргэнд ачаад 3 толгой тахьтай хамт дасгах хашаанд идээшүүлэхээр авчирсан юм. "Парадайз" гүү түүнийг өөртөө дасгаж авсан нь дахиад л азтай хэрэг байв. 2016 оны 6-р сарын дундуур 4 толгой тахийг суллаж тавьсан бөгөөд Хонин усны баянбүрдээр дамжин тэд баруун зүгийн Тахийн уснаас ирсэн сүрэг тахьтай нийлжээ. 7-р сард тэд сүргийг зүүн хил рүү дагалдан явсан бөгөөд Хаан азарганы сүрэгтэй нийлцгээсэн. 2016 оны 11-р сард тэд Ховд азаргатай сүрэгт нийлсэн байна. Энэ жилийн 5-р сарын эхээр Ховд азарга Цуут үрээг өөрийн сүргээс хөөсөн нь залуу азаргануудын хувьд ердийн л хувь тавилан юм. Тахь цөөн байдаг Говийн их дархан цаазат газрын "Б" бүсийн баруун хэсэгт Цуут нь тодорхой сүрэггүйгээр бүх зүйлийг бие даан туулсан цорын ганц азарга юм. Чонын сүрэг эргэлддэг ийм газар ганцаараа байх нь амар зүйл бишээ. Цуут өөрийн сүргээ бүрдүүлэн авах хүртлээ нилээд хэдэн жил тэсвэрлэх хэрэгтэй болох нь. Бид түүгээр бахархаад зогсохгүй, түүнд сайн сайхныг хүсэх нь зүйтэй.



2018 онд сүргийн тоо толгой хамгийн их буюу 223 тоо толгойд хүрчээ. Гэсэн хэдий ч энэ тоо бага, эмзэг хэвээр тул эдгээр сүргийг хамгаалах шаардлагатай юм.

Төрөл зүйл амьтан: Аргаль

Аргаль нь дэлхийн хамгийн том зэрлэг хонь бөгөөд Америкийн бүдүүн эвэрт хонь болон Евроазийн моуфлонтой дүйцэхүйц амьтан юм. Амьдрах таатай уугуул орчин нь бага зэрэг налуу, өндөр гүвээ, өндөрлөг газрууд юм. Өнөө үед үлдсэн сүргүүд нь Казакстанаас Хятад хүртэлх асар том орон зайд тархсан байдаг.³ Монголд аргалийн сүрэг нь Монгол Алтайн нуруу, Алтай, Хангайг дамнасан уул нурууд болон Говийн уулархаг бүсүүдэд амьдардаг. Улаан номд мэдээлснээр аргалийн сүргийн тоо толгой бараг 10% -иар буурсан байна. Бодит гаргасан тоо байхгүй хэдий ч улаан номын тоо баримтаас харахад Алтайд хэдэн мянган аргаль, харин говьд 10,000 орчим аргаль байдаг байна. Аргаль нь монголын баруун хэсэгт урьд өмнө нутаглаж байсан бол өдгөө тоо толгой, тархац нь нэлээд хумигджээ.

Төв Азийн бусад улс орнуудад аргаль амьдрах нөхцөл байдал их эрсдэлтэй ба Казакстанд жишээ нь автомат буугаар агнадаг бол Киргизстанд 2005-2006 оны хооронд бараг 40% нь устсан гээд олон жишээ бий. Энэ нь дэлхийн хэмжээний сүргийн тоо буурсан гэсэн үг юм. Хэт ихээр агнах, хулгайгаар агнах болон мал сүргээс өвчин халдварлан дамжих гэх мэт түгээмэл шалтгаанаар аргалийн тоо буурч байна.

Аргалийг хууль бусаар болон гадаадын анчдад агнуулах зөвшөөрлийг хэтрүүлэн олгох, хятадын уламжлалт анагаах ухаанд эвэрнээс гарах кератин хэмээх бодисыг хэрэглэж байгаа болон хүн ам, тэдний малын тоо толгойн өсөлт нь аргаль хонины тархац бэлчээр нутагт сөргөөр нөлөөлж, тоо толгой багасах гол шалтгаан болж байна.

Уул уурхай, газрын доорх баялгийг олборлох явдал нэмэгдсэнтэй холбоотойгоор зэрлэг амьтдын амьдрах орчин хумигдаж, тоо толгой нь улам бүр багассаар байна.

Аргаль тархсан хамгаалалттай бүс нутагт хуулийн хэрэгжилт сул байгаа ба дээр дурьдсан аюул заналын шалтгаанууд байсаар байгаа нь анхаарах асуудал болж байна. Монгол Улсад аргаль нь 2001 оноос "цөөрсөн" амьтдын жагсаалтад орсон ба 2006 оноос Алтайн аргаль "устах аюулд" орсон амьтны жагсаалтад орсон. Аргалийг 1953 оноос агнахыг хориглож ирсэн. 2005 онд CITES Хавсралт 2-ын дагуу аргаль агнаж экспортлох зөвшөөрлын квот нь 80 болгон тогтоож байжээ.

Зөвшөөрөлтэй ан агнуур нь онолын хувьд байгаль хамгаалах үйл ажиллагааны санхүүжүүлэлтэд нэмэр болж болох юм. 1995 онд батлагдсан ан агнуурын тухай хуулиар Алтайн аргаль угалз тутамд 18,000 ам. доллар, Говийн аргаль угалзад 9.000 ам. доллар байхаар тогтоожээ. Түүний 70% нь улсын орлого, 20% нь орон нутгийн орлого, харин



Зургийг: Марсель Хүйжсэр

Аргаль нь дэлхийн хамгийн том зэрлэг хонины төрөл юм. Тархан байгаа газарт нь зэрлэг амьтад, хөөж тууснаас үүдэн тоо толгой нь хорогдож байгаа. Монгол аргалийн тоо огцом буурч байна. /Дэлхийн Улаан номын үнэлгээгээр 24 жилд 3 үеийн сүрэг 30% -иар буурсан/



Райнхард Шнидриг, Улаанбаатар хотын ан олзворын музейд байрлах дэлхийд алдартай хамгийн том гэж тооцогдсон аргалийн эвэр - толгойны дэргэд байгаа нь

Зөвшөөрөлтэйгөөр ан агнахыг сайтар төлөвлөж, тооцоолж, хянахгүй бол сүргийн тоо толгойг ноцтойгоор бууруулдаг.


³ Харрис, Р.Б. & Рийдинг, Р. 2008. (Ovis ammon). Дэлхийн байгаль хамгаалах холбооны ховор зүйлүүдийн улаан жагсаалт 2008: e.T15733A5074694. <http://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2008.RLTS.T15733A5074694.en>. Zugriff am 31. 5-р сар 2018.

Монгол Улсад аргаль нь 2001 оноос "цөөрсөн" амьтдын жагсаалтанд орсон ба 2006 оноос Алтайн аргаль "сүйрэх аюулд" орсон амьтны жагсаалтад орсон.

10% нь орон нутгийн ан агнуурын нийгэмлэгт тушаахаар заасан байдаг. Байгууллагуудад төлсөн орлогын 90% нь бүс нутгийн хүн ам болон албан ёсны хамгаалалтын үйл ажиллагаанд зарцуулагдах учиртай юм. Гэвч бодит байдал дээр ашиг тусыг нь хүртэгсэд тун бага байна.⁴

2002 онд Монгол улсын байгаль орчны яам болон дэлхийн байгаль хамгаалах сан нь аргаль хамгаалах болон менежментийн хөтөлбөрийг боловсруулан гаргасан боловч төдийлөн хэрэгжээгүй. Монголд аргаль хонь өсөн үржих таатай орчинг бүрдүүлэх шаардлагатай ба гаргасан зааврыг мөрдөж, одоо үйлчилж байгаа хуулиа сахин биелүүлэх нь чухал юм. Аргалийн сүргүүд тархсан газарт хамгаалагчид илүү олон байхыг хэрэгтэй ба орон нутгийн иргэд аргаль байгаа газраас санхүүгийн хувьд ашигтай байж, хамгаалалтын үйл ажиллагаагаараа дамжуулан аялал жуулчлал гэх мэт зүйлсийг явуулах боломжтой юм.

Америк дахь бүдүүн эвэрт хонины тархалт



Хойд Америк дахь бүдүүн эвэрт хонины тархалт

Хойд Америк дахь бүдүүн эвэрт аргаль хонины тоо толгой эхлээд эрс буурч, тархалт нь тусгаарлаж байсан хэдий ч сайн хамгааллын үр дүнд дахин өсөж, нэмэгдэж ирсэн.



АНУ-ын Колорадо, Аляск болон бусад мужуудад зэрлэг хониний фото-аялал жуулчлал улсад багагүй орлого оруулах салбар болон хөгжиж байна.

Хулан ус даган нүүдэллэдэг

Өвс тэжээл тарчиг газар амьдарч байгаа том өвсөн тэжээлтэн нь улирлаас хамааран нүүдэллэхээс илүүтэйгээр урьдчилан таамаглашгүй, том орон зайг хамран нүүдэллэж байдаг. Үүний учир шалтгааныг нь бараг судлаагүй ба өвс ургамлын хэлбэлзлээс хамаардаг боловч хэмээн таамагладаг. Монголын талд бэлчих хулан бэлчээрийн асар том орон зайд нүүдэллэн бэлчдэг байна. Д.Нандинцэцгээр ахлуулсан монгол, олон улсын эрдэмтдийн баг нь хулангийн асар том газар нутгийг хамран нүүдэллэх шалтгаан нь чухам юу болохыг судалжээ.⁵ Зургаан жилийн ажиглалт, тооллолын үндсэн дээр уг судалгааг хийжээ. Сүргийн нүүдэллэх шалтгаан болсон өвс ургамлын ургах үетэй харьцуулан судалсан ба үржил шимтэй өвс ургамал нь хуланг нүүдэллэх гол хүчин зүйл болохыг олж тогтоосон боловч жилийн турш, олон жилийн явцад нүүдэллэх нь харьцангуй хэлбэлзэлж байгааг харуулжээ. Мөн хулан нь ус унднаас 21 км-ээс хол нүүдэлдэггүй ажээ. Хэрэв телеметрийг нэмэлтээр зүүлгэсэн бол хаана ус байгааг алсаас мэдэх ба энэ нь хуланг алс хол нүүдэллэх үндсэн шалтгаан болдог байна. Иймд зохиогчийн зүгээс засгийн газар болон байгаль хамгаалагчдад хандан хуурай экосистемтэй газрын ан амьтад зориулан аль болох усны хангамж, ус ундаргын хүртээмжийг бий болгох тал дээр анхаараасай хэмээн зөвлөж байна.




4 С.Амгаланбаатар, Р.Рийдинг, Б.Лхагвасүрэн, Н.Батсүх., 2002. Монгол орны аргаль хонины (*Ovis ammon*) трофей агналт. *Pirineos* 157: 129-150.

5 Дэжидийн Нандинцэцэг, Петра Каченски, Оюунсайханы Ганбаатар, Петер Лаймгубер, Томас Муллер:

Эрс тэс хүрээлэн буй орчин дахь туруутан амьтдын цаг хугацаа-орон зайн амьдрах орчны динамик: Монгол орны говь цөл дэх хулан (*Equus hemionus*)-гийн судалгааны ажил. Биологийн хамгаалал, 2016, <https://doi.org/10.1016/j.biocon.2016.10.021>

Монгол Улсад Аргалийн тоо сүргийг өсгөж, үржүүлэхийн тулд 2002 онд гаргасан хамгаалах, менежментийн зөвлөмжийг даган мөрдөх шаардлагатай юм.



Тахийн тоо толгой оргил үедээ

2009/2010 оны өвлийн зуднаас хойш тахийн сүрэг хурдан өсөж үржсээр ирсэн. 2018 онд оргил үедээ буюу тоо толгой нь 223 / эдгээрээс 23 нь энэ жилийн унага байв/ болж өсчээ. Бусад 35 гүү одоо хээлтэй байгаа бөгөөд тоо толгой нь 250 –д хүрч болохоор байна. Гэсэн хэдий ч энэ тоо бага, эмзэг тул эдгээр сүргийг хамгаалах шаардлагатай юм.

Өөрчлөлтөд дасан зохицох нь

Лена Михлер, магистр

Говийн их дархан цаазат газрын “Б” бүсийн өргөн уудам тал нутагт зөвхөн тахь, хулан төдийгүй хувийн мал аж ахуй эрхэлдэг малчид амьдардаг. Гэвч энэхүү уламжлалт амьдралын хэв маяг ирээдүйд ч гэсэн байх боломжтой юу? Монголын малчид хотжилт, орчин үеийн өөрчлөлт, цаг уурын өөрчлөлттэй нүүр тулгарч байна. Говийн их дархан цаазат газрын “Б” бүсэд одоогоор 40 орчим малчин өрх, мал сүрэгтэйгээ өвөлжин, хаваржиж байна. Гэсэн хэдий ч залуу хойч үеийнхэн нүүдлийн хэв маягаа үргэлжлүүлэх үү? Говийн их дархан цаазат газрын “Б” бүсийн малчид дан ганц мал сүргийнхээ ашиг шимээр амь зууж чадах уу? Тус хамгаалалттай нутгийг өргөжүүлэхдээ малчдын бэлчээр ашиглалтыг хэрхэн зохицуулах вэ? Эдгээр асуултыг тодруулахаар миний бие ХБНГУ-ын Хохэнхаймийн их сургуульд докторантурт Доктор Петра Каченскийн удирдлагад сурч байна. Бидний судалгааны зорилго нь хэрэглэж болохуйц бэлчээрийн менежментийн стратегийг орон нутгийн малчид болон хамгаалалтын газрын менежментийн багийнхантай хамтран боловсруулахад оршино. Бид нийгэм, эдийн засаг ба экологийн асуудлуудыг хослуулсан шинэлэг аргачлалыг ашиглаж байна. Дархан цаазат газрын менежментэд малчдыг татан оролцуулах асуудал урьдынх шиг хомс байна. Нэг талаас байгаль хамгаалахад жинтэй хувь нэмэр оруулж буй, нөгөө талаас уламжлалт мал аж ахуйн үндэс суурь болж буй байгалийн цогцолборт, дархан цаазат газруудад, ялангуяа нөөц хязгаарлагдмал болон экосистемийн хувьд цаг уураас шууд хамааралтай Говийн их дархан цаазат газрын “Б” бүсэд судалгаа шинжилгээ хийх шаардлага урьдын хэвээр их байна.

Бэлчээрийн тогтвортой байдлыг хангахын тулд сурвалжлага, туршилт, орчныг ажиглах болон компьютерийн тусламжтайгаар менежмент стратегийн зөв бодлогыг хослуулах нь зүйтэй юм. Үүнийг хийхдээ бид орон нутгийн малчид болон Говийн их дархан цаазат газрын “Б” бүсийн менежментийн багийнхантай нягт хамтран ажиллах юм. Говийн их дархан цаазат газрын “Б” бүс орчмын 80 гаруй малчин өрх айлтай зөвлөлдөх юм. Мөн түүнчлэн хонь, ямааны бэлчээр, тэдний хөдөлгөөний загварыг гаргахын тулд жилийн туршид 20 хонь, ямаанд GPS хүүзүүвч зүүж зайнаас тандан судлах юм. Мөн тахь, хулан, зээр, ямаа,

хонь, тэмээ, үхэр болон монгол адууны аргал, хомоолд DNA –ын судалгаа хийж тэдний хооллох хамгийн дуртай өвс, тэжээл, идшийг мэдэх боломжтой ба гэршүүлсэн болон зэрлэг амьтдын бэлчээрийн асуудал, өрсөлдөөнийг тодорхойлж болох юм. Өвс, тэжээл, ургамлыг туршилтын газар судалснаар нийт хамгаалалтын газрын олон төрөл ургамлыг мэдэх боломжтой. Хөрсний шим тэжээлийн тархалтыг малчдын амьдарч буй газрын хөрсийг шинжлэн дүгнэн гаргах ба хөрсний үр хөврөлийн үрүүдийн тоо болон төрөл зүйлийг туршилтаар гаргана. Эдгээр мэдээлэл нь Зүүнгарын говийн малчдын өнөөдрийг хүртэл хамаарч ирсэн нөхцөл байдал буюу Говийн их дархан цаазат газрын малчдад тулгарч буй нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон бэлчээрийн экосистемийн ерөнхий дүр зургийг харуулах юм.



Лена Михлэр (арын эгнээнд зүүн гар талаас 2 дох нь) нь О.Ганбаатар захирагчтай Тахийн Талийн хамт олонтой: Зургийг: Хүмэйр Хаяат.

Нэг сантиметр сүүлний үс юу өгүүлэх вэ.

Байгаль дахь изотопийн (ялгаатай жинтэй химийн элементийг агуулсан атом) хуваарилалт нь температураас хамааран өөрчлөгдөж байдаг. Үүнийг NASA (EOSDIS)-ийн ажиглалтын мэдээллээс олж харж болно. Ийм замаар сүүлний үсийг шинжилж, өвөл, зуны хэмнэлийг олж мэдэж болно. Энэ нь сүүлний үс нэг см ургахад хуланд дунджаар 19 хоног, тахинд 17 хоног ба монгол адуунд 13 хоног болдог гэдгийг тооцоолох боломжийг олгож байгаа юм²⁴. Ургалтын хурд нь тухайн зүйл амьтнаас хамаарч өөр өөр байдаг. Энэхүү мэдээллийг ашиглан тахийн музейгээс авсан сүүлний үсийг шинжилэхэд тахь хулантай адилхан өвс тэжээлээр хооллодог, өвснөөс гадна мөн бут иддэг байсан үе буюу тэдгээрийн устахаас өмнөх сүүлчийн үе шат гэж харагддаг.

24 Марина Бурник Штурм, Будхан Лукаценти, Долорес Рийд, О.Ганбаатар, Стэйн Сашник, Агнес Хэймири, Христиан С. Войгт болон Петра Каченски : Нийтлэг цагийн шугаманд салангидаар тайрсан сүүлний үсний изотоп сигнатурыг жагсааж, сүүлний үсний ургалтын дотоод ба хоорондын шинж чанарын ялгаатай байдлыг засварлах протокол. Массын спектрометрээр яаралтай харилцан мэдээлэх, 2015 оны 6 сарын 15;29(11):1047–54. doi: 10.1002/gcm.7196.

Байгаль хамгаалагчтай хийсэн ярилцлага: Жамъяандоржийн Батсүх

2018 оноос эхлэн Монгол дахь олон улсын тахь группийн хамт олон эмэгтэй ажиллах хүчнээр багаа хүчирхэгжүүлсэн юм. Говийн их дархан цаазат газрын “Б” бүсэд хэрэгжүүлж буй хөтөлбөрт дэмжлэг хэрэгтэй тул ажилд авах нухацтай шалгуурын дагуу Жамъяандоржийн Батсүхийг “Хөтөлбөрийн менежер”-ийн ажилд томилсон юм. Ж. Батсүх нь ХБНГУ-ын Нүртинген Их сургуульд Олон улсын менежмент мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан ба SDC, GiZ, Азийн сан, Улаанбаатар хотын Хилтон зочид буудал зэрэг үндэсний болоод олон улсын байгууллагуудад ажилласан 18 гаруй жилийн туршлагатай. Тэрээр герман, англи, орос хэлээр чөлөөтэй ярихаас гадна маш эрч хүчтэй эмэгтэй юм. Тэрээр Элантай хамтран “Тахийн нөхөд” хэмээх монгол дох нийгэмлэгийг өргөжүүлэн тэлэхийн зэрэгцээ богино хугацаанд олон тооны боломжит ивээн тэтгэгчидтэй холбогдох, спонсор олж үр дүнтэй ажилласнаар Олон улсын тахь группийн Удирдах Зөвлөлд өндөр сэтгэгдэл төрүүлсэн юм. Ийм үр дүнтэй дэмжлэг нь Олон улсын тахь группт үнэ цэнэтэй.

ОУТГ: Батсүхээ, та морины талаар хэр сайн мэдэх вэ?

Батсүх: Би Тахь сангийн хамт олонтойгоо ажиллаж эхлэхээс өмнө морины тухай тийм ч сайн мэддэг байгаагүй. Нэг удаа Денверт /АНУ, Колорадо муж/ солонгос хүн намайг “морь унаж чаддаггүй монгол хүнийг анх удаа харлаа” хэмээн ёжилж, хорыг минь малтсан юм. Гэхдээ одоо би морины талаар, ялангуяа тахийн талаар ер нь л их зүйлийг мэддэг болоод байгаа.

ОУТГ: Таны мэргэжлийн ур чадвар Монгол дахь Олон улсын тахь группийн хамт олонд үнэ цэнэтэй мэдлэг туршлага болж, тус дэм болж байна. Та яагаад манай байгууллагад ажиллах болсон бэ?

Батсүх: Би Олон улсын тахь группийн зорилго, хийж буй ажил болон үүнийг гүйцэтгэсэн хүмүүсийг хараад баярласан. Хэдийгээр би өөрөө тахь үржүүлж, эмчилж чадахгүй ч хуримтлуулсан мэргэжлийн туршлагаа ашиглаад менежмент, зохион байгуулалтын ажил болон бизнес удирдлага, судалгаа хийн, дэмжлэг үзүүлж чадах юм.

ОУТГ: Та ОУТГ-д ажилласнаар 3 жилийн дараа ямар болсон байх бол?

Батсүх: Юуны түрүүнд, би “Тахийн нөхөд” сангийн гишүүнээр аль болох илүү олон залуусыг гишүүнээр оруулахыг хүсч байна. Манай экосистем ямар эмзэг, байгаль орчноо хамгаалах нь ямар ач холбогдолтой болохыг залуу үеийнхэн ойлгож ухамсарлах нь маш чухал. Мөн үйл ажиллагаандаа орон нутгийн малчид, олон нийтийг оролцуулах хүсэлтэй байна. Шинэ гишүүн болсноор үнэ цэнэтэй, сайн дурын байгаль хамгаалагчид болох юм.

ОУТГ: Монгол дахь “Тахийн нөхөд” санг дэмжиж, доноруудад итгэл үнэмшил хэрхэн төрүүлэх вэ?

Батсүх: Нэгдүгээрт, уг ажил 26 жилийн өмнө эхэлсэн ба гадаадын хөрөнгө оруулагч хувь хүмүүс, амьтны хүрээлэн, паркуудаас тусламж хандив авах байдлаар амжилттай хэрэгжсээр ирсэн. Одоо монголчууд бидний хувьд энэхүү өгөөмөр ариун ажил үйлст илүү идэвхтэйгээр оролцож, дэмжих цаг нь болоод байна. Өнгөрсөн 26 жилд Европоос нийт 124, түүнээс ч олон тахийг агаараар тээвэрлэн авчирсан. Тахийг эргэж нутагшуулсан ба хамгаалалтан дор дахин үржүүлэх явдал нь бидний үүрэг юм. Мэдээж Говийн их дархан цаазат газар нь улсын байгууллага боловч нэмэлт дэмжлэг туслалцаа нэн чухал.



Хоёрдугаарт, Тахийн нөхөд нь зөвхөн тахийг дэмжээд зогсохгүй, мөн Монгол улсын хувьд чухалд тооцогдох Говийн их дархан цаазат газрын бүхэл бүтэн эко системийг дэмжиж байгаагаараа онцлогтой. Энэхүү экосистем нь онцлог учраас бид ирээдүй хойч үедээ, үр хүүхдүүддээ өвлүүлэн үлдээх нь чухал юм. Энэ бүс нутгийн нүүдэлчдийн тухайд экосистемээс хамааралтай тул илүү ихээр оролцох шаардлагатай.

ОУТГ: Хэдийгээр Монгол Улс сүүлийн 10 жилд асар их эдийн засгийн өсөлттэй байсан ч хүн амын ихэнх нь хангалуун сайхан амьдарч чадахгүй байна. Говийн экосистемийг хамгаалах, ялангуяа маш ховордсон амьтдын төрөл зүйлийн ач холбогдлыг хүмүүс ойлгож мэдрэх болов уу?

Батсүх: Үнэн, энэ тийм хялбар зүйл биш. Гэхдээ бид хэн нэгэн бидэнд туслахыг хүлээхгүйгээр уг ажилд оролцох шаардлагатай гэдгийг ойлгох хэрэгтэй байна. Бид монгол хүмүүс, өөр газар очиж амьдрахгүй нь лавтай, энэ бол бидний л улс орон. Одоо л хамгаалахгүй бол хэтэрхий оройтно.

Бидний хувьд маш бага хандив туслалцаа, гишүүний татвар ч гэсэн бүгдийг тооцоотой хийдэг. Бүгдээрээ нийлээд хийх юм бол илүү их амжилтанд хүрэх нь ойлгомжтой.

ОУТГ: Улсынхаа эдийн засгийг хөгжүүлэх, байгалийн үзэсгэлэнгээ хамгаалах хамгийн тохиромжтой зүйл нь юу гэж харж байна вэ?

Батсүх: Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд хамгийн тохиромжтой секторууд нь үнэт цаасыг бий болгогч бүтээгдэхүүн ба нөөцийн бүтээгдэхүүн юм. Эдийн засгийн хөгжил нь тогтвортой хөгжлийг бий болгоно. Энгийн үгээр хэлэхэд хэн нэгэн нь нөөц эсвэл үржүүлсэн үнэт цаасаа зараад мэдээжээр их мөнгө олж болно гэж ойлгодог ч бэлчээр талхлагдан, нөөц нь олборлогдсон хойно цаасан мөнгөөр үүнийг дахин худалдаад авах ямар ч боломжгүй юм. Мөн бидний үр хүүхдүүд бэлчээр байхгүй болчихсон бол өөрсдийнхөө үнэт цаас, хувьцааг өсгөөд ч яах юм билээ? Бидний өвөг дээдэс байгальтай хэрхэн харьцаж байсан талаар ч бид дахин бодох шаардлагатай болж байна. Саяхан би Говь-Алтай, Ховд аймгуудад малчид ямааны ноолуураа самнах цагаар очиж таарлаа. Зарим малчид 500-1000 тоо толгой бүхий ямаатай байгааг хараад би гайхсан. Яг үүнтэй зэрэгцээд малчид бэлчээрийн доройтлын талаар гомдоллож байна. Мэдээж дэлхийн дулаарал нөлөөлж байгаа хэдий ч малчид ийм олон тооны ямаатай байх шаардлага байна уу хэмээн би бодож байлаа. Биднийг тэжээж байгаа зүйлээ устгаж байгаа юм шиг санагдсан. Гэвч энэ нь том асуудлын нэг хэсэг нь юм.

ОУТГ: Батсүхээ, таны энэ их хичээл зүтгэлд бид талархаж байна. Таны цаашдын ажил үйлсэд өндрөөс өндөр амжилтыг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе!

Хамтдаа бүтээцгээ!

Эрхэм хүндэт уншигч та бидний үйл ажиллагаа, хөтөлбөрийг ямар нэгэн байдлаар дэмжихийг (веб дизайн, харилцаа холбоо, хөгжлийн тусламж, барилга, төслийн менежмент гэх мэт) хүсвэл Олон улсын тахь групп буюу (itgmon@gmail.com, takhifriends@gmail.com) хаягаар холбогдоорой. Тахь, түүний

экосистемийн хамгаалаах үйлсэд сайн дураараа зүтгэж буй манай хамт олон бүхий л төрлийн дэмжлэг туслалцааг хүлээн авахдаа таатай байна. Говийн эко системийг хамгаалах үйлс их тул манай УЗ болон УЗ-с гадуурх санал санаачлагыг хүлээн авахдаа баяртай байх болно. Мөн та Тахийн талыг өөрийн нүдээр харж, үнэ төлбөргүй буудаллах боломж байгааг дуулахад таатай байна.

Тахь бол анхдагч зэрлэг адуу

Нарийн гаргаж ирсэн мэдээлэл дээр үндэслэн энэхүү урьдчилсан дүгнэлтийг өгч болох юм. Нэг талаараа төсөөлөлтэй нийцэж болох ч нөгөө талаараа бодит байж ч болох юм. Судлаачдын баг “Шинжлэх Ухаан” сэтгүүлийн нэгэн нийтлэлд генетикийн дүгнэлтээр тахь адууны өвөг дээдэс (*Equus przewalskii*) нь Ботай-Соёл (МЭӨ 4000 жил)-д⁶ хамаарах гэршүүлсэн адуу байж болох юмб хэмээн бичжээ. Гэвч зарим эрдэмтэд үүнтэй санал нийлдэггүй байна.^{7, 8, 9, 10}

Энэ нь нэг талаасаа 44 мориноос авсан ясны геномик дүн шинжилгээн дээр, нөгөө талаас археологийн олдворууд дээр үндэслэсэн бөгөөд адууны хүзүүвчнээс олдсон ул мөр, нядалгааны газар гэмээр хашааны үлдэгдэл, керамик хэсгүүд дээр дүрсэлсэн гүүний сүүн тослог, адууны шүдний эмгэг зэрэг ул мөрөөс ийнхүү дүгнэжээ. Үүнээс үндэслэн Ботайчууд зэрлэг адууг гэршүүлэх зорилгоор агнаснаас болж өөрчлөгдсөн гэж дүгнэжээ.

Ботай-Адууны генетикийн судалгаагаар адууны үүсэл гарал, ургийн модонд түүнийг тахийн дээр оруулсан байдаг ба зохиогчийн үзэж байгаагаар өнөөгийн тахь нь гэршүүлсэн Ботай-Адуунаас гаралтай гэж үзжээ.

Энэ нь Ботайчууд 300м² хашаандаа тухайн үеийн бүх зэрлэг адууг барьж хэрэглэсэн эсвэл баригдаагүй нь үр төлөө үлдээгээгүй болж таарах нь.

Энэхүү түүх нь илүү ухаалгаар тайлбарласан эсвэл хий хоосон зүйлийн аль аль нь ч байж болно. Эхлээд Төв Азийн тал нутагт бэлчиж байсан зэрлэг адууг Ботайчууд барьж, нядалж, сүүлдээ бас сургажээ – зэрлэг адууны талаарх бүхий л боломжит хувилбар – өөрөөр яах байсан гэж? Тэд өнөөгийн тахьтай генетикийн хувьд нягт хамаатай гэдэгт гайхах

зүйлгүй. Хоёрдугаарт, уналганд хэрэглэнэ гэдэг нь сургаж номхруулсан цаа буга, заан, бусад зэрлэг ан амьтдыг гэрийн амьтан болгосонтой адилхан зүйл. Гуравдугаарт, 5000 жилийн настай генетикийн сорьц нь ямарваа нэг хангалттай магадлагаагаар филогенетикийн модыг тайлбарлах боломжийг олгохгүй.⁸ Дөрөвдүгээрт, нэг амьтанд суурилсан филогенийн тооцооллыг сүргийн генетикийн асуудлын хувьд зохиогчид нь зохисгүй байдлаар ашигласан байна.¹⁰

Энэ мэдээллээс Ботай- Адуу нь тахийн шууд элэнц хуланц байсан гэх дүгнэлтийг хийх боломжийг олгохгүй байгаа ч гэсэн Ботай-Адуу нь өнөөгийн тахийн үүссэн зэрлэг адуунаас үүдэлтэй юм.

Эцэст нь эдгээр олон академик нотолгоо, баримтаас үл хамааран тахь нь эртний адууны төрлийн үлдэж хоцорсон цорын ганц төлөөлөл юм. Ийм ч учраас бид тахийг сайтар хамгаалж, авч үлдэх нь чухал юм. Ийнхүү хамгаалах нь аливаа нэгэн малтлагад таамаг дэвшүүлэхээс хамаагүй илүү, чухал зүйл юм шүү.

6 Гауниц С болон бусад; Тахь болон гэрийн адууны гарал үүслийг эргэн харах генетикийн судалгаа. Шинжлэх ухаан 2018, 360 (6384):111-114.

7 Валцерь С болон бусад; Тахь гэрийн адуутай хамгийн ойрын төрөл хэдийч зэрлэг хэвээр үлдсэн цорын ганц зүйл. Цахим захидал, Шинжлэх ухаан сэтгүүлд, 17.5.2018: <http://science.sciencemag.org/content/360/6384/111/tab-e-letters>, accessed 30.5.2018

8 Бойд Л болон бусад; Өөрсдийн адууг хадгалан үлдэе Цахим захидал, Шинжлэх ухаан сэтгүүлд, 1.5.2018: <http://science.sciencemag.org/content/360/6384/111/tab-e-letters>, accessed 30.5.2018

9 Лаймгрубер П болон бусад; Тэд байгальд зэрлэгээрээ байсаар ирсэн: Тахь адуу хамгийн шилдэг нь байсаар ирсэнийг баталсан судалгаа. Цахим захидал, Шинжлэх ухаан сэтгүүлд, 4.5.2018: <http://science.sciencemag.org/content/360/6384/111/tab-e-letters>, accessed 30.5.2018

10 Ворл С болон бусад. Бэлтгэл



Зургийг: Ребякка Блумер



25'000 жилийн настай агуйн зургуудад өнөөгийн тахьнаас бараг ялгахааргүй зэрлэг адууг дүрсэлжээ.

Академик олон нотолгоо, баримтаас үл хамааран тахь нь эртний адууны төрлийн үлдэж хоцорсон цорын ганц төлөөлөл. Ийм ч учраас бид тахийг сайтар хамгаалж, авч үлдэх нь чухал юм.

Таны тусламж бидэнд хэрэгтэй

Та хандив өгөхийг хүсвэл бидэнд хандаарай.

Байгаль хамгаалах ажил нь тийм ч сүр дуулиантай байдаггүй. Ялангуяа дадал болсон ар талын ажлыг амжилттай төсөл болгох нь амаргүй ажил юм.

Тиймээс таны өгсөн хандив тусламжаар хичнээн өөрчлөлт хийж болохыг та эндээс харж болно. Өгч буй хандив бүр бидэнд үнэ цэнэтэй ба хүлээн авахдаа бид таатай байна.



40,000 төг

Хамгаалагчийн нэг өдрийн хөлс
(цалин, материалын зардал)



120,000 төг

Унааны шатахууны зардал



200,000 төг

Байгаль хамгаалагчдын машины
засвар сэлбэг.



300,000 төг

Аргаль, Янгирт зориулсан нарны
эрчим хүчээр ажилладаг гүний
худаг барихад зориулна



500,000 төг

Байгаль хамгаалагчдийн нэг сарын
унааны зардал



1 000,000 төг

2020 онд зэрлэг ан амьтдыг тоолох
байгаль хамгаалагчдад зориулсан
сургалтад хувь нэмрээ оруулна.

Олон улсын тахь групп нь сайн дурын үндсэн дээр ажилладаг ба таны хандивласан төгрөг бүр тахь хамгаалахад зориулагдана.

"Тахийн нөхөд" сангийн гишүүн болох боломж Танд байна!

- Хувь хүний жилийн хураамж **90,000 төгрөг**

- Оюутан, залууст зориулсан "унага" гишүүний хураамж **35,000 төгрөг**

Хандивын данс

Худалдаа Хөгжлийн Банк

Дансны дугаар: 499114883 ам. Доллар
499248691 төгрөг

Олон улсын тахь группийн
Монгол дахь товчоо

Холбогдох

Олон улсын тахь групп
Тахийн нөхөд сан
Нэт капитал оффис, 3-р давхар
Чингэлтэй дүүргийн 4-р хороо
Сүхбаатарын гудамж
Улаанбаатар -15141
Монгол улс
www.savethewildhorse.mn
itgmon@gmail.com
takhifriends@gmail.com



ITG INTERNATIONAL TAKHI-GROUP



Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв